



АРХАНГАЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 04 сарын 13 өдөр

Дугаар 1/62

Эрдэнэбулган сум

2020 оны цэрэг татлагын ажлыг
зохион байгуулах тухай

Улсын Онцгой комиссын 2020 оны 8 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2020 оны А/224 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2020 оны нэгдүгээр ээлжийн цэргийн жинхэнэ албаны цэрэг татлагын үеэр цэрэгт татагдах иргэдийг коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тушаалын хавсралтаар баталсан үйл ажиллагааны чиглэлийн дагуу бэлэн байдлаа хангаж ажиллахыг сумдын Засаг даргын тамгын газар, сумын эрүүл мэндийн төвүүдийн дарга нар, Эрдэнэбулган сумын 5 дугаар сургуулийн захирал нарт тус тус үүрэг болгосугай.

3. Цэрэг татагдах иргэдэд эрүүл мэндийн үзлэг, оношилгоо хийх эмч нарыг томилж, үзлэг, оношилгооны үед коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр баримтлах халдвар хамгааллын дэглэмийг танилцуулж, 1 удаагийн хамгаалах хувцас хэрэгсэл, амны хаалт, бээлий, гар халдваргүйжүүлэх уусмал, шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангаж, хариуцлагатай ажиллуулахыг Нэгдсэн эмнэлгийн дарга, сумын эрүүл мэндийн төвүүдийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга /Д.Алтантуяа/-д даалгасугай.

ДАРГА



Р.ГАНДИЙМАА

6510000020

Эрүүл мэндийн газрын даргын
2020 оны 04 сарын 13 ны өдрийн
А/Х дугаар тушаалын хавсралт

Цэрэгт татагдах иргэдийг коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх
чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

1. Цэрэгт татагдах иргэдэд эрүүл мэндийн үзлэг, оношилгоо хийх байрыг урьдчилан цэвэрлэж, халдваргүйжүүлэх
2. Цэрэгт татагдах иргэдэд үзлэг, оношилгоо хийх байрны дотор болон гадна талд хоорондоо 2 метр зайтай байхаар тэмдэг, тэмдэглээ тавих
3. Гараа савандаж угаах нөхцөлийг бүрдүүлэх
4. Гар халдваргүйжүүлэх уусмалыг хүртээмжтэй байрлуулах
5. Үзлэг, оношилгоо хийж байгаа өрөө тасалгаанд өдөрт 3-аас доошгүй удаа чийгтэй цэвэрлэгээ, 2 цаг тутамд агааржуулалт хийх
6. Хаалганы бариул гэх мэт хүний гар их хүрдэг хэсгүүдийг 2 цаг тутам халдваргүйжүүлэх
7. Үзлэг хийж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтэн, бусад төрийн албан хаагчид, цэрэгт татагдах иргэд бүгд амны хаалт зүүх
8. Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмж, санамжийг үзлэг, оношилгоо хийх байрны гадна, дотно талд байрлуулах
9. Үзлэг, оношилгоо хийж байгаа эмч нар амны хаалт зүүж, гар халдваргүйжүүлэх уусмалыг тогтмол хэрэглэж, /шаардлагатай тохиолдолд бээлий өмсөх, гарыг савандаж угаах/, үйлчлүүлэгчийн биед хүргэсэн үзлэг, оношилгооны багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмжийг тухай бүр зааврын дагуу халдваргүйжүүлж, дараагийн хүнд хэрэглэн халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиж ажиллах